



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сайхандулаан сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/11/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: DORNOGOVI@AUDIT.GOV.MN

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 70523020 Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Аудитор: У.Оюунтүлхүүр

Утас: Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	9
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	9
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	10
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	11
2.11.	Шилэн дансны мэдээлэл	12
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	12
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	13
3	Менежментийн захидал	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14

1 Аудитын гэрчилгээ

20/25 2-8/1397


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийг өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019. 03. 25 № 1-6/348

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Сайхандулаан сумын төсвийн Төвлөрүүлэн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сайхандулаан сумын төсвийн Төвлөрүүлэн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Сайхандулаан сумын төсвийн Төвлөрүүлэн захирагч нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Сайхандулаан сумын төсвийн Төвлөрүүлэн захирагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Н.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Сайхандулаан сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Эрдэнэжаргалд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Сайхандулаан сумын Засаг дарга 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхандулаан сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.14-наас 2018.03.16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын аудитор У.Оюунтүлхүүр хариуцаж хэрэгжүүлэв.

Сайхандулаан сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.03.04-ны өдрийн 1/86 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Сайхандулаан сумын Засаг дарга талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Сайхандулаан сумын Засаг дарга нь Сумын эдийн засаг нийгмийн хөгжлийг тогтвортой ахиулах үйл явцыг багийн зарчмаар гүйцэтгэх, мэргэшсэн албан хаагч бүхий албыг ажиллуулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

(Үйл ажиллагааны чиглэлийг тогтоосон шийдвэрийн нэр)-р Сайхандулаан сумын Засаг дарга үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын төвлөрсөн удирдлага

Сайхандулаан сумын Засаг дарга удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 8 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 8 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Сайхандулаан сумын Засаг дарга эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр						
№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	5	1		4	
2	ТТЗ	1	2			
	Дүн	6	3		4	

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сайхандулаан сумын Засаг дарга мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сайхандулаан сумын Засаг дарга санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Сайхандулаан сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн програм хангамж ашигладаггүй байна.

Сайхандулаан сумын Засаг дарга дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Сайхандулаан сумын Засаг дарга бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр цэвэр хөрөнгийн 2 хувиар сонгов.

Цэвэр хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатны суурийг хэвээр авсантай холбоотой юм.

Сайхандулаан сумын Засаг даргын 2018 оны цэвэр хөрөнгө 2947173.2 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь Сайхандулаан сумын засаг даргын 6 байгууллага 3 ЗГСангийн ТШЗ-ын санхүүгийн аудитаар ЕБСургууль хязгаарлалттай дүгнэлт авсан бөгөөд энэ хязгаарласан зөрчлийн тархалтыг тогтоох зорилгоор тус дүнгээс дээгүүр тогтоож үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Сайхандулаан сумын Засаг дарга болон төвлөрүүлэн захирагчын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 37309.9 мянга, төсвийн төвлөрүүлэн захирагчын хэмжээнд 22350.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 25725.1 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангилалаар үзүүлэв. Үүнд:

2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Асуудал 1: Зардал

ЕБСургууль багш ажилчдад улирал бүр олгодог үр дүнгийн урамшуулал цалингийн үнэлгээг сар бүр үнэлээгүй улиралд нэг удаа үнэлсэн, хувь хэмжээг нь илүү болон дутуу олгож үр дүнгийн улирлын шагналт цалинг илүү болон дутуу олгож Засгийн газрын 2017 оны 346 дугаар тогтоолыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн

Асуудал 1: Худалдан авалт болон гэрээний хэрэгжилт

ЕБСургууль 2018 оны жилийн төсөвт тусгагдсан 17246,0 мянган төгрөгийн хүүхдийн хоолны санхүүжилтийг ТБОНӨХБАҮХАТХуулийг зөрчин иргэнтэй шууд гэрээ байгуулан санхүүжилтийг олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Үүнээс: Залруулгын ангилал

№	Залруулгын товч утга	Мөнгөн дүн (мянган төгрөгө өр)	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой	Тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	Өмнөх тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлттэй холбоотой
----------	-----------------------------	---------------------------------------	--	---	---	--

1	СХСангийн зээлийн хүүгийн авлагыг үр дүнгийн тайланд дутуу тусгасан	13580.5	13580.5	
2	СХСангийн зээлийн хүүг тооцож авлагаар бүртгэсэн мөртлөө авлагыг бууруулалгүй дахин үр дүнд тайлагнасан	8770.1		8770.1
	Дүн	22350.6	13580.5	8770.1

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	0	0.00	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Сайхандулаан сумын Засаг дарга чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 120 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 976075.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Аймгаас авах санхүүгийн дэмжлэг 258069.7 мянган төгрөг, татварын болон татварын бус орлого 26558.0 мянган төгрөг баталж СЗТГ болон ИТХ-ын санхүүжилт 284627.7 мянган төгрөгөөр баталсан байна. Аймгаас санхүүгийн дэмжлэг 258069.7 мянган төгрөг, татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл 23370.2 мянган төгрөг, /төсөвт байгууллагын өөрийн орлогыг хассан дүнгээр/ нийт 281439.9 орлого орсон.

Үүнээс СЗДТГ болон ИТХ-ын санхүүжилт 281255.5 мянган төгрөг буюу 3372.2 мянган төгрөг дутуу санхүүжүүлсэн байна. Жилийн эцэст СЗДТГ болон ИТХ 309.8 мянган төгрөгийн үлдэгдлээ төвлөрүүлж сумын ерөнхий орлогын дансны үлдэгдэл 494.3 мянган төгрөгийг аймагт төвлөрүүлэн ажилласан байна.

Татварын болон татварын бус орлогын гүйцэтгэлийг авч үзвэл:

№	Орлогын төрөл		2018 оны баталсан төсөв	2018 оны 12 сар тодотгол	Гүйцэтгэл /хуулгаар/	Зөрүү	хувь
1	Үйл ажиллагааны орлогын албан татвар	911	6850000	650000	631180	-18820	97.10
2	Бусад татвар	912 914	14300000	16365400	11849939.84	-4515460.16	72.41
3	Бууны татвар	922	1050000	1050000	1132000	82000	107.81
4	Улсын тэмдэгтийн хураамж	941	800000	800000	704950	-95050	88.12
5	Хог хаягдал үйлчилгээний хураамж	947	2358000	2358000	3068000	710000	130.11
6	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	948	100000	100000	150000	50000	150.00
7	Төсөвт байгууллагуудын өөрийн орлого		1000000	1000000	1152000	152000	115.20
8	Хадгаламжийн хүүгийн орлого	975		4104600	4614141.66	509541.66	112.41

Сайхандулаан сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

9	Хөрөнгө борлуулсны орлого	962		30000	50000	20000	166.67
10	Хүү торгуулийн орлого	952	100000	100000	1170000	1070000	1170.00
Нийт орлого			26558000	26558000	24522211.5	-2035788.5	92.33

Хувь хүнээс суутгасан орлогын албан татварын төлөвлөгөө 4515.5 мянган төгрөгөөр тасарсан нь арьс ширний урамшуулал ороогүйгээс шалтгаалсан гэсэн тайлбар өгсөн.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Сайхандулаан сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 50 хувьтай байна. 2017 оны аудитаар Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хугацаа хэтэрсэн 15 иргэний зээл, зээлийн хүүгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж өгсөн. Хугацаа хэтэрсэн зээлтэй иргэдийн судалгааг гаргаж аймгийн прокурорын газарт хүргүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Сайхандулаан сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 43.1 хувь буюу 25725.1 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 51.2 хувь буюу 30555.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 5.7 хувь буюу 3379.8 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

(Мянган төгрөг)

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ			2	22351.0	2	22351.0	2	22351.0
2	ТШЗ	10	33935.4	1	3374.5	11	37309.9		
3	ТБӨААН								
	Дүн	10	33935.4	3	25725.5	13	59660.9	2	22351.0

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

(Мянган төгрөг)

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
		1	ТТЗ										
2	ТШЗ	10	33935.4			3	30555.6	7	3379.8				
3	ТБӨААН												
	Дүн	10	33935.4			3	30555.6	7	3379.8				

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сайхандулаан сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Сайхандулаан сумын Засаг дарга 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан			Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	

Сайхандулаан сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	ТШЗ	4	1	5
2	ТТЗ	1		1
	Дүн	5	1	6

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	324,511,739.15	329,427,149.84
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	52,389,805.29	29,671,670.28

Сайхандулаан сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	52,389,805.29	29,671,670.28
31210	Төгрөг	52,389,805.29	29,671,670.28
31211	Төрийн сангийн харилцах	52,389,805.29	29,671,670.28
33	АВЛАГА	164,965,085.00	195,570,413.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	321,691.00	422,868.00
33500	Бусад авлага	856,501.00	325,243.00
33510	Байгууллагаас авах авлага	852,501.00	284,641.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	4,000.00	40,602.00
33600	Зээлийн авлага	163,786,893.00	194,822,302.00
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	163,786,893.00	194,822,302.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	163,786,893.00	194,822,302.00
35	БАРАА МАТЕРИАЛ	106,583,568.86	104,159,186.56
35100	Түүхий эд материал	2,656,817.73	3,431,851.03
35130	Эм боох материал	2,656,817.73	3,431,851.03
35400	Хангамжийн материал	99,050,751.13	95,839,935.53
35410	Бичиг хэргийн материал	2,005,095.00	2,193,820.00
35420	Аж ахуйн материал	65,665,066.83	63,942,599.83
35430	Сэлбэг хэрэгсэл	1,173,900.00	628,900.00
35440	Түлш, шатах тослох материал	16,421,801.30	16,224,297.70
35450	Барилгын засварын материал	0.00	0.00
35460	Хүнсний материал	5,969,002.00	4,225,432.00
35470	Бусад хангамжийн материал	7,815,886.00	8,624,886.00
35600	Мал амьтад	4,876,000.00	4,887,400.00
36	НӨӨЦИЙН БАРАА	573,280.00	25,880.00
36100	Барааны нөөц	25,880.00	25,880.00
36600	Бусад нөөц	547,400.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,464,316,883.69	2,618,483,394.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,464,316,883.69	2,618,483,394.16
39200	Биет хөрөнгө	2,463,652,717.05	2,573,913,994.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,254,460,358.00	1,870,976,169.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	-546,289,516.53	-267,849.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	165,570,190.00	210,960,190.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-19,117,674.98	-16,017,846.01
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	531,470,327.26	316,487,741.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	-178,069,368.32	-144,102,723.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	123,116,105.27	117,422,136.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	-62,202,781.29	-73,702,004.50
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,014,450.00	2,014,450.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	197,232,676.00	473,851,654.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,537,763.36	-186,803,439.80

Сайхандулаан сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39217	Ном	2,005,715.00	3,095,515.00
39300	Биет бус хөрөнгө	664,166.64	44,569,400.00
39301	Програм хангамж	1,903,800.00	22,372,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,239,633.36	-1,402,600.00
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	23,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,788,828,622.84	2,947,910,544.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,889,669.37	737,344.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,889,669.37	737,344.00
41300	Өглөг	2,889,669.37	737,344.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	924,580.00	640,865.00
41360	Бусад өглөг	1,965,089.37	96,479.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,922,909.37	44,381.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	42,180.00	14,758.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	0.00	37,340.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,785,938,953.47	2,947,173,200.00
51	Засгийн газрын хувь оролцоо	2,785,938,953.47	2,947,173,200.00
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,627,338,848.05	1,671,057,048.05
51200	Хуримтлагдсан үр дүн	946,026,937.64	655,666,763.28
51210	Өмнөх үеийн үр дүн	877,732,276.82	1,075,243,684.45
51220	Тайлант үеийн үр дүн	68,294,660.82	-419,576,921.17
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	212,573,167.78	620,449,388.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,788,828,622.84	2,947,910,544.00

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,577,183,904.97	1,684,988,551.82
11	ТАТВАРЫН ОРЛОГО	27,271,530.81	22,200,211.50
110	Орлогын албан татвар	22,116,280.81	17,145,261.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	22,116,280.81	17,145,261.50

Сайхандулаан сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

110002	Үйл ажиллагааны орлого	6,746,330.00	681,180.00
110008	Шууд бус орлого	15,369,950.81	16,464,081.50
113	Хөрөнгийн албан татвар	1,156,000.00	1,132,000.00
113002	Бууны албан татвар	1,156,000.00	1,132,000.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	3,999,250.00	3,922,950.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,999,250.00	3,922,950.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	705,250.00	704,950.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	150,000.00	150,000.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3,144,000.00	3,068,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	134,330,933.16	353,518,267.32
120	Нийтлэг татварын бус орлого	134,330,933.16	353,518,267.32
120002	Хүүгийн орлого	4,538,104.75	1,235,459.99
120003	Торгуулийн орлого	160,000.00	1,170,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	122,262,828.41	325,781,857.33
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,434,000.00	3,304,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60,000.00	16,859,547.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	116,768,828.41	305,618,310.33
120009	Бусад орлого	7,370,000.00	25,330,950.00
